

## ХАРИЛЦАГЧИЙН ГАРЫН АВЛАГА

### **Танилцуулга**

Монголын хөрөнгийн бирж нь Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ил тод, таатай орчныг бүрдүүлэхажлын хүрээнд Лондонгийн хөрөнгийн бирж, Борса Италиана /Италийн хөрөнгийн бирж/, Иоханнесбургийн хөрөнгийн бирж зэрэг дэлхийн олон орны хөрөнгийн биржүүдэд ашиглагддаг Миллениум Ай Ти системийг Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлж, улмаар үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны систем T+3 горимд шилжлээ.

Түүнчлэн, бид бүхэн хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулахаар Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/ болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үнэт цаасны бүртгэл, арилжаа, төлбөр тооцооны журмуудыг шинэчлэн батлаад байна. Энэхүү шинэчлэгдсэн дүрэм, журмуудыг МХБ-ийн албан ёсны цахим хуудаснаас харах боломжтой. (<http://www.mse.mn/>).

### **Данс нээхэд тавигдах шаардлагууд**

Хөрөнгө оруулагчид МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцоход дараах 3 төрлийн данс нээх шаардлагатай. Үүнд:

1. **ҮЦТТХТ-ийн данс:** Энэ нь Монголын Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд (ҮЦТТХТ) нээгдэх данс юм. Хөрөнгө оруулагчид арилжаанд оролцохын тулд ҮЦТТХТ-д үнэт цаасны данс нээлгэх шаардлагатай бөгөөд энэ нь дансан дахь үнэт цаасны бүртгэл байнгын хяналтанд байхыг баталгаажуулж буй хэрэг юм. ҮЦТТХТ-д данс нээлгэхийн тулд харилцагч нь дараах мэдээлэл, бичиг баримтыг брокерийн компанидаа өгч, ҮЦТТХТ-д Данс нээлгэх гэрээ байгуулах шаардлагатай. Үүнд:
  - а. Овог нэр;
  - б. Оршин суугаа улс;
  - в. Иргэний үнэмлэхний хуулбар;
  - г. Холбоо барих мэдээлэл (хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг);
  - д. Банкны дансны мэдээлэл (Төлбөр тооцоо гүйцэтгэгч банктай холбоотой хэсгийг харна уу).

Брокер нь дээрх мэдээллүүдийг харилцагчаас хүлээн авсны дараа данс нээлгэх бичиг баримтыг ҮЦТТХТ рүү цахим хэлбэрээр илгээнэ.

Данс нээгдсэний дараа харилцагч нь интернетээр дансаа шалгах үйлчилгээг авах боломжтой ба үүний тулд маягт<sup>1</sup> бөглөж, ҮЦТТХТ-д хүргүүлнэ.

2. **БРОКЕРИЙН ДАНС.** Энэ нь МХБ-ийн шинэ дүрэм, журмаар тавигдаж буй шаардлагыг хангаж, арилжаанд оролцох эрх авсан аль нэг брокерийн компанийд нээгдсэн данс

<sup>1</sup>Маягтыг [http://www.schcd.mn/wp-content/uploads/2011/03/Internet\\_Service\\_EN.pdf](http://www.schcd.mn/wp-content/uploads/2011/03/Internet_Service_EN.pdf) - аас авах боломжтой.

юм(арилжаанд оролцох эрхтэй компаниудын жагсаалтыг МХБ-ийн <http://www.mse.mn/members> цахим хуудаснаас авах боломжтой). Данс нээлгэхэд дараах ерөнхий шаардлагууд тавигдана<sup>2</sup>.

- Үүнд:
- a. Иргэний хувьд:

- i. Иргэний үнэмлэх (Монгол улсад биечлэн байхгүй тохиолдолд нотариатаар баталгаажуулсан хувь)
- ii. ҮЦТТТХТ-д данс нээлгэх гэрээ.

- b. Хуулийн этгээдийн хувьд:

- i. ҮЦТТТХТ-д данс нээлгэх хүсэлт;
- ii. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь;
- iii. ҮЦТТТХТ-д данс нээлгэх гэрээ;
- iv. Дансан дахь хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийг томилсон тухай ТУЗ, эсхүл Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;
- v. Дансыг захиран зарцуулах эрх бүхий этгээд, албан тушаалтны нотариатаар баталгаажуулсан гарын үсгийн баталгааны загвар;
- vi. Данс захиран зарцуулагчийн иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь.

2006 оны 7-р сарын 8-ны өдөр батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар Монголын брокерийн компаниуд нь харилцагчаасаа дараах мэдээллийг авах үүрэгтэй гэж заасан.

- Үүнд:
- a. Хэрэв харилцагч нь иргэн бол, түүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь;
  - b. Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол, хуулийн этгээдийн нэр, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний болон татвар төлөгчийн дугаар, холбоо барих утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь, удирдлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

### 3. ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭГЧ БАНКНЫ ДАНС.

Эн нь таны үйлчлүүлдэг брокерийн компанийн сонгосон төлбөр тооцоо гүйцэтгэгч банкинд байрших арилжааны мөнгөн төлбөр тооцоо гүйцэтгэх, ноогдол ашгийг төвлөрүүлэх зорилготой тусгай (тусгай нөхцөлтэй эскроу данс) данс юм<sup>3</sup>. 2012 оны 7-р

<sup>2</sup>Энэхүү жагсаалт нь брокерийн компаниас шаардах ерөнхий шаардлагууд бөгөөд компани бүр өөрийн дотоод журмынхаа дагуу үүнээс ялгаатай эсвэл нэмэлт шаардлага тавьж болно.

<sup>3</sup>2012 оны 8-р сарын 1-ний өдрийн байдлаар Монгол банкнаас Голомт банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк гэсэн 4 банкинд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эрхийг олгосон байна.

сарын 2-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон ҮЦТТХТ-ийн Төлбөр тооцооны шинэ журмаар төлбөр тооцоо гүйцэтгэгч банкинд данс нээхэд тавигдах шаардлагуудын талаар тусгасан бөгөөд дараах ерөнхий шаардлагууд тавигдана<sup>4</sup>.

Үүнд:

*a. Иргэний хувьд:*

- i. Тусгай нөхцөлтэй эскроу данс нээлгэх хүсэлт /банкнаас маягтыг авна/;
- ii. Харилцагчаа таних маягт /банкнаас маягтыг авна/;
- iii. Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь;
- iv. Нотариатаар баталгаажуулсан гарын үсгийн баталгааны загвар /банкнаас маягтыг авна/;
- v. Брокерийн компанийтай байгуулсан зуучлалын гэрээний хувь.

*b. Хуулийн этгээдийн хувьд:*

- i. Тусгай нөхцөлтэй эскроу данс нээлгэх хүсэлт /банкнаас маягтыг авна/;
- ii. Харилцагчаа таних маягт /банкнаас маягтыг авна/;
- iii. Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь;
- iv. Дансыг захиран зарцуулах эрх бүхий этгээд, албан тушаалтны нотариатаар баталгаажуулсан гарын үсгийн баталгаа /банкнаас маягтыг авна/;
- v. Брокерийн компанийтай байгуулсан зуучлалын гэрээний хувь.

2006 оны 7-р сарын 8-ны өдөр батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар Монголын төлбөр тооцоо гүйцэтгэгч банкууд нь харилцагчаасаа дараах мэдээллийг авах үүрэгтэй.

Үүнд:

- a. Хэрэв харилцагч нь иргэн бол, түүний эцэг, эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь;
- b. Хэрэв харилцагч нь хуулийн этгээд бол, хуулийн этгээдийн нэр, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний болон татвар төлөгчийн дугаар, холбоо барих утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь, удирдлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Түүнчлэн, банк тус бүр өөрсдийн нэмэлт шаардлагуудыг тогтоож болно. Жишээлбэл, хэдийгээр хуулиар данс нээлгэхдээ заавал биечлэн ирэх тухай заагаагүй ч, төлбөр тооцоо гүйцэтгэгч банк нь харилцагчийг биечлэн ирэх эсвэл Монгол улсын иргэнд олгосон итгэмжлэлийн дагуу данс нээлгэх шаардлага тавьж болно.

---

<sup>4</sup>Энэхүү жагсаалт нь Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкнаас шаардах ерөнхий шаардлагууд бөгөөд банк бүр өөрийн дотоод журмынхаа дагуу үүнээс ялгаатай эсвэл нэмэлт шаардлага тавьж болно.

## Гадаадын хөрөнгө оруулалтад тавигдах хязгаарлалт

Одоогийн байдлаар Монголд орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалтанд тавигдсан хатуу шаардлага байхгүй ч “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль”-иар дараах стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагчдад тусгай шаардлага тогтоосон<sup>5</sup>. Үүнд:

- Уул уурхай;
- Банк, санхүү;
- Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо.

## Хавсралт. Хэрэгцээт холбоосууд

1. МХБ-ийн цахим хуудас: <http://www.mse.mn/>
2. ҮЦТТХТ-ийн цахим хуудас: <http://www.schcd.mn/?lang=en>
3. Монголбанкны цахим хуудас: <http://www.mongolbank.mn/eng/default.aspx>
4. СЗХ-ны цахим хуудас:  
[http://www.frc.mn/engnew/index.php?option=com\\_content&view=frontpage&Itemid=1](http://www.frc.mn/engnew/index.php?option=com_content&view=frontpage&Itemid=1)

Хэрэгцээт мэдээллийн эх үүсвэрийг дараах хаягаар авна уу.

1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль-  
[http://www.mse.mn/doc/law/english/en\\_investment\\_law.pdf](http://www.mse.mn/doc/law/english/en_investment_law.pdf)
2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /албан бус орчуулга/ -  
[http://www.mse.mn/doc/law/english/en\\_sec.pdf](http://www.mse.mn/doc/law/english/en_sec.pdf)
3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль:  
<http://www.mongolbank.mn/documents/cma/cma1eng.pdf>
4. Компанийн тухай хууль - [http://www.mse.mn/doc/law/english/en\\_company.pdf](http://www.mse.mn/doc/law/english/en_company.pdf)
5. МХБ-ийн дүрэм, журмууд - <http://www.mse.mn/content/show/id/40>

---

<sup>5</sup>Хуулийн товч агуулга нь стратегийн ач холбогдол бүхий салбарт 33.3%-иас дээш хөрөнгө оруулах гадны хөрөнгө оруулагчид Засгийн газраас зөвшөөрөл авах, 50%-иас дээш хөрөнгө оруулах бол УИХ-аас зөвшөөрөл авах тухай заасан. Мөн томоохон хөрөнгө оруулагчдыг бүртгэхэд тавигдах тодорхой шаардлагуудыг тусгасан. Дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол, хуулийн зөвлөхтэйгөө холбоо барина уу.